

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН СОЛОНГОС АРД УЛС

(Товч лавлах)

Ц. Баатар

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ) Азигийн Зүүн хойт хэсэг буюу Солонгосын хойгийн умард хэсэгт оршино. 122,1 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай. Хүн ам 21,4 сая, (1990 оны байдлаар) хүн ам нь үндсэндээ солонгосчууд юм. Цөөн тооны хятад угсаатан бий. Шашин шүтлэгийн хувьд олон янз. Зохилох шашин нь бурхны, христосын, лалын шашин болно. Нийслэл Пхеньян (1 сая гаруй хүн сууна). Улсын хэл-солонгос.

Солонгосчууд өнө эртний баялаг түүхтэй ард түмэн. Солонгос угсаатан оршин тогтносоор 5 мянга гаруй жилийн нүүр үзэж байна. Буурал түүхийнхээ нугачаанд солонгосчууд том гүрнүүдийн сөргөлдөөн колоничлолын золиосонд хэдэнтээ өртөж, асар их зовлон зүдгүүр туулсан ард түмэн билээ.

1910 онд Солонгосыг Япончууд эзлэн авч 1945 он хүртэл ноёрхож байв.

ЗХУ-ын (хуучин нэрээр) арми Солонгосын партизануудын хамтаар солонгосын хойгийг Японы ноёрхлоос чөлөөлсөн боловч Солонгос дахь японы цэргийг буулгаж авах ажлыг дэлхийн хоёрдугаар дайнд гитлерийн германы эсрэг холбоотон байсны хувьд ЗХУ, АНУ хоёр хамтран хариуцаж гүйцэтгэхээр тохиролцсон байна. Үүний дагуу АНУ 1945 оны есдүгээр сард Солонгосын нутгийн өмнөд хэсэгт цэрэг оруулжээ. Ийнхүү Солонгос дахь Японы армийг буулган авч, колонийн засаг захиргааг устгаж улмаар Солонгосын төв засгийн газрыг байгуулах хүртэл түр хугацаагаар тус улсын умард хэсэгт Зөвлөлтийн цэргийн командлал, өмнөд хэсэг америкийн цэргийн командлалын хяналтад орших ёстой байв.

1945 оны арван хоёрдугаар сард Москва хотноо болсон ЗХУ, АНУ, Их Британы ГЯЯ-ны сайд нарын зөвлөлгөөнөөр Солонгос нь нэгдмэл, тусгаар тогтносон ардчилсан улс байх ёстойг хүлээн зөвшөөрч, Солонгосын түр засгийн газрыг байгуулах нь зүйтэй гэж тохиролцсон юм. Гэвч их гүрнүүдийн сөргөлдөөний улмаас солонгосын хойг хоёр хэсэгт хуваагдсан билээ.

Солонгосын Ардын Дээд хурлыг сонгох бүх нийтийн сонгуулийг 1948 оны наймдугаар сард орон даяар зохион явуулжээ. Ардын Дээд Хурлын анхдугаар чуулганаас 1948 оны есдүгээр сарын 9-нд БНАСАУ байгуулсныг тунхаглан зарлав.

ЗХУ, БНАСАУ-ыг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрч, 1948 оны аравдугаар сард дипломат харилцаа тогтоож, мөн оны эцсээр тэндээс цэргээ гаргасан байна.

1946 онд Солонгосын коммунист нам, Ардын шинэ намтай нэгдэж Солонгосын хөдөлмөрийн нам (СХН) байгуулжээ. Мөн үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд, тариачдын зэрэг олон нийтийн байгууллагууд бий болжээ.

1945—1948 онд Умард Солонгост Солонгосын хөдөлмөрийн намын удирдлагын доор газрын шинэтгэл явагдаж газар эзэмших, түрээс-

лэх системийг халж, газрын шинэтгэл хийн, аж үйлдвэрийн газруудыг улсын болгож, тээвэр, холбоо, банк, гадаад худалдааг улсын болгох зэрэг өөрчлөлт шинэчлэлт явуулж, Японы колоничлолын үеийн эвдлэн сүйтгэсэн үйлдвэрлэлийн хүчин чадлыг сэргээжээ. БНАСАУ-д явагдаж байсан энэ шинэчлэл төдий л удаан үргэлжилж чадсангүй. 1950 оны зургаадугаар сарын 25-нд хоёр солонгосын хооронд дайн дэгдсэн байна.

1950—1953 он хүртэл үргэлжилсэн дайны уршгаар БНАСАУ-ын эдийн засаг сүйрлийн байдалд хүрч, ардчилсан өөрчлөлтүүд бүрэн тасалдсан байна. Дэлхийн олон нийтийн шаардлагын үрээр Солонгосын хойгт дайны галыг зогсоох тухай Хэлэлцээрт 1953 оны долоодугаар сарын 27-нд гарын үсэг зурснаар БНАСАУ энхийн бүтээн байгуулах их үйлсдээ оржээ.

БНАСАУ дайны дараах үед ЗХУ, хуучин социалист гэгдэж байсан Зүүн европын орнуудын тусламжид тулгуурлан дайны хүнд шархыг арилгасан төдийгүй, үндэсний эдийн засгийн бат бэх суурь тавьжээ. 1972 онд баталсан шинэ үндсэн хуулинд БНАСАУ социализмын замаар цаашид замнах болно гэдгийг бататган заажээ.

БНАСАУ дэлхийн 100 орчим оронтой дипломат харилцаатай. 1991 онд БНАСАУ, БНСУ нэгэн зэрэг НҮБ-д гишүүнээр элссэн. НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай өргөн харилцаатай.

1972 оны Үндсэн хуулийн ёсоор БНАСАУ-ын хууль тогтоох дээд байгууллага нь дөрвөн жилээр сонгогддог Ардын Дээд Хурал (АДХ) юм. Чуулганы завсар хооронд АДХ-ын Байнгын Зөвлөл уг эрхийг барьдаг. Төрийн тэргүүн нь ерөнхийлөгч болно (АДХ-аас 4 жилийн хугацаагаар сонгодог).

Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний дээд командлагч байдаг. Ерөнхийлөгч нь засаг төрийн удирдах дээд байгууллага-Ардын Төв Хороог (АТХ) толгойлдог. АТХ нь захирамжлах ба гүйцэтгэх байгууллага-Засаг захиргааны зөвлөлийг эмхлэн байгуулдаг. БНАСАУ-ын ерөнхийлөгч нь Ким Ир Сен. Тэрээр 1948 оноос хойш БНАСАУ-ын нам, төрийн тэргүүнээр тасралтгүй улиран сонгогдож албан үүргээ гүйцэтгэж байна. 1992 оны дөрөвдүгээр сарын 15-нд 80 нас хүрчээ. Ард түмэн нь Аугаа их удирдагч хэмээн тахин шүтдэг. Өөрийн хүчинд тулгуурлан хөгжих тухай Чучхе-ийн онолыг үндэслэгч юм. Энэ дашрамд өгүүлэхэд 1990 оны байдлаар Ази, Африк, Латин Америкийн 26 оронд Чучхе-гийн үзэл санааг судлах үндэсний хороо, 67 оронд 1000 гаруй байгууллага байдаг ажээ.

СХН-ын мөрийн хөтөлбөрт «социализмыг бүрэн төгс байгуулах, бүх орны хэмжээгээр үндэсний эрх чөлөөний, ардчилсан хувьсгал хийж дуусгах, эх орноо нэгтгэх, эцсийн зорилго нь коммунист нийгэм байгуулах явдал юм» гэж тунхаглажээ. СХН-ын төв хэвлэл нь «Нодон синмун», улс төр-онолын сэтгүүл нь «Кыллоджа».

СХН бол солонгосын эх орны ардчилсан нэгдмэл фронтын (СЭОАНФ) тэргүүлэх хүч юм. Уг фронтод солонгосын ардчилсан нам, «Чхондогё чхонудон» нам (Тэнгэрийн замын шашны залуу анд нарын нам), мөн олон нийтийн байгууллага-Солонгосын нэгдсэн үйлдвэрчний эвлэл, Солонгосын хөдөө аж ахуйн хөдөлмөрчдийн холбоо, Солонгосын социалист хөдөлмөрчин залуучуудын холбоо, Солонгосын ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо тус тус багтдаг.

БНАСАУ өөрийн хүчинд тулгуурласан үндэсний эдийн засгийг байгуулах чиг шугамыг чанд баримтлан хүнд үйлдвэрийг тэр дундаа олборлох, боловсруулах үйлдвэрийг түлхүү хөгжүүлж, үүнийхээ зэрэгцээ хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуйг зэрэгцүүлэн эрчимтэй хөг-

жүүлснээр бусдын гарыг харахгүй амьдарч чадах биеэ даасан орон болжээ. БНАСАУ-ын эдийн засаг өөрийн түүхий эд, техникт түшиглэж байгаа болохоор цаашид эрчимтэй хөгжих боломжтой юм. Энд жишээ болгож аж үйлдвэр, хөдөө ажа хуйн салбарын үйлдвэрлэлийн талаар цухас өгүүлье.

БНАСАУ өнгөт, хар, эрдэсийн болон төмөрлөгийн хүдэр, нүүрс, бал, магнезит, бусад ашигт малтмалын үлэмж нөөцтэй. Эдийн засгийн тэргүүлэх салбар нь аж үйлдвэр. Хар болон өнгөт металл, эрчим хүч, нүүрс, хими, барилгын материал, гэр ахуйн болон аж үйлдвэрийн салбаруудад зориулсан цахилгаан хэрэгсэл, хөлөг онгоц, төрөл бүрийн авто болон суурь машин, нэхмэл, хөнгөн ба хүнсний зэрэг олон салбаруудтай. Эдгээрийн дотроос хамгийн эрчимтэй хөгжиж байгаа нь металл боловсруулах болон машины үйлдвэрийн салбар юм. Бүр Японы колоничлолын үеэс солонгосын хойгийн энэ хэсгийг аж үйлдвэрийн чиглэлээр хөгжүүлж байсан учир дайн самууны хөлд хэдийгээр сүйрсэн ч гэсэн хүнд хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх суурь нэгэнт тавигдсан байжээ. Өнөөдөр БНАСАУ металл зүсэгч болон нарийн ажиллагаатай бусад зориулалтын янз бүрийн суурь машинууд, гинжит, дугуйт трактор, илчит болон цахилгаан галт тэрэг, 20—50 мянган тооны даацтай загас агнуурын зориулалттай, тээврийн зориулалттай усан онгоц, өргөгч цамхаг, дотоод шаталтын хөдөлгүүр, генератор, трансформатор, компрессор, насос зэргийг үйлдвэрлэж байна. Мөн хөргөгч, телевизор зэрэг гэр ахуйн болон аж үйлдвэрийн зориулалттай цахилгаан хэрэгслийн үйлдвэр нэлээд хөгжсөн байна. Түүнчлэн БНАСАУ виналоны болон төрөл бүрийн бордоо үйлдвэрлэдэг томоохон үйлдвэр олонтой. Жишээ болгон Сунчхоны виналоны үйлдвэр, Саривоны калийн бордооны үйлдвэр зэргийг нэрлэж болох юм. Сунчхоны виналоны үйлдвэр нь жилд нэг сая тонн карбит кальци, 750 мянган метанол, 100 мянган тонн виналон, 900 мянган тонн азотын бордоо, 250 мянган тонн каустик, 400 мянган тонн кальцийн давс, 300 мянган тонн уурагт тэжээл үйлдвэрлэдэг юм. Саривоны калийн бордооны үйлдвэр нь жилд 3 сая тонн калийн хүдэр боловсруулж 510 мянган тонн калийн бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай юм. БНАСАУ олоо калийн бордооныхоо дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна.

БНАСАУ өнөөгийн байллаар жилдээ 56—60 тэрбум квт цаг эрчим хүч, 70—80 сая тонн нүүрс, 16 сая тонн төмрийн хүдэр, 1 сая тонн өнгөт төмөрлөгийн хүдэр, 6—7 сая тонн ширэм, 7—8 сая тонн ган, 5—6 сая тонн цувимал, 12—13 сая тонн цемент үйлдвэрлэдэг ажээ.

БНАСАУ-ын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх төлөвлөгөө зохиогдоо 7 жилээр төлөвлөдөг. Энэ жилд гуравдугаар долоон жилийн төлөвлөгөөний сүүлчийн жил юм. Улс ардын аж ахуйг хөгжүүлэх гуравдугаар 7 жилийн (1987—1993) төлөвлөгөөний эцэст 10 сая тонн ган, 1,5 тэрбум метр нэхмэл, бөс бараа, 15 сая тонн үр тариа үйлдвэрлэх зорилт тавьжээ. Дээрхи зорилт биелэгдвэл 1946 оныхоос 1100 дахин их бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм байна.

БНАСАУ-ын хөлөө аж ахуйн гол салбар нь газар тариалан юм. Уулархаг орон учраас газар нутгийнхаа зөвхөн 16-хан хувь буюу 2 сая орчим га талбайг боловсруулж тариаланд ашигладаг. Ихэнх талбайгаас жилд хоёр удаа ургац авдаг. Хөлөө аж ахуйн гол ургамал нь тутарга, эрдэнэ шиш, арвай, шар буурцаг, төмс зэрэг ургамал юм. Бүх талбайн гуравны хоёрт нь цагаан буяа, тавны нэгд нь техникийн ургамал, үлдсэн хэсэгт нь төмс, хүнсний ногоо, алим, улаан

буудай, шар буурцаг, арвай, хөвөнгийн ургамал, чихрийн нишэнгэ, тамхи, хүн орхоодой тариалдаг. Өнөөгийн байдлаар нэг га-гаас цагаан будаа 7,6 тонн, эрдэнэ шиш 6,5 тонныг хураан авч байгаа нь өндөр үзүүлэлт юм. БНАСАУ-д газрыг хамгаалах, арчлан тордох талаар онцгой анхаарал тавьдаг. 1977 онд батлагдсан 6 бүлэг 80 зүйлтэй газрын тухай хуулинд Газар бол төрийн онцгой өмч болохыг заагаад түүнийг бүх талаар ариглан хамгаалах, арчлан тордох, үр өгөөжтэй ашиглах зэрэг газрын харилцаатай холбогдсон бүх асуудлыг хуульчлан баталгаажуулжээ.

БНАСАУ нь торгоны болон ойн аж ахуйгаас гадна мал аж ахуйг хөгжүүлдэг. Шувууны аж ахуй нэлээд эрчимтэй хөгжиж байна. Жилдээ 2 сая орчим тонн загас, далай тэнгисийн бүтээгдэхүүн олборлож байна.

Тус улсын үндэсний нийт бүтээгдэхүүн үнийн дүнгээр 1989 онд 21 тэрбум ам. долларт хүрчээ. Нэг хүнд ногдох нийгмийн нийт бүтээгдэхүүн 987 ам. доллар байв. Улсын жилийн нийт төсөв 14,9 тэрбум ам. доллар, түүнээс 4,49 тэрбум ам. долларыг цэргийн зардалд зориулж байна. 1989 онд Умард Солонгосын импорт 2,9 тэрбум ам. доллар, экспорт 2 тэрбум ам. доллар, гадаад өр 6,8 тэрбум ам. доллар байв.

БНАСАУ-ын засаг төрөөс ард түмний соёл боловсролыг хөгжүүлэх чиглэлээр авсан олон талт арга хэмжээний үр дүнд энэ салбарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарчээ. 1975 оноос бүх нийтийг 11 жилийн боловсролтой болгох зорилт дэвшүүллээ. Сургалтын системийн онцлог гэвэл бүх нийтэд үнэ төлбөргүй боловсрол олгох явдал юм. Боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх нэг жилийн сургалт, 4 жилийн сургалттай бага сургууль, 6 жилийн сургалттай бүрэн дунд сургууль, 4 жилийн сургалттай их дээд сургуулиудаас бүрддэг. Аль ч шатны сургуульд сургалтын чанарт их анхаарал тавьдаг. Хүмүүс ч чанартай сурахыг эрхэмлэнэ. Энэ нь үндэсний эдийн засгийн хөгжлийг түргэтгэх үйл хэрэгт мэргэжилтэй боловсон хүчний гүйцэтгэх үүрэг роль улам бүр өсөн нэмэгдэж, үйлдвэрлэлд нарийн ажиллагаатай техник, технологи өргөн нэвтэрч байгаатай холбоотой. Өнөөгийн байдлаар Хойд Солонгост 1,5 сая гаруй хүнтэй сэхээтний бүхэл бүтэн том арми ажиллаж байна.

БНАСАУ-д шинжлэх ухаан техникийн салбарт хийж гүйцэтгэх ажлыг 3 жилээр төлөвлөдөг, улс орны өмнө тавигдсан тулгамдсан зорилтыг хэрэгжүүлэхэд эрдэмтдийн хүч анхаарлыг төвлөрүүлж тэдэнд хөрөнгө, техникийн бүх талын тусламж дэмжлэг үзүүлж байнга хөхүүлэн дэмждэг аж. Үүний үр дүнд металл зүсэх суурь машин, цахилгаан техникийн үйлдвэрлэлд дэвшил гаргаж, үйлдвэрлэлийн дамжлагыг автоматжуулах чиглэлээр мэдэгдэхүйц амжилт олсон байна. Түүнчлэн биологи, биотехнологийн салбарт ч амжилт гаргажээ. БНАСАУ-ын Шинжлэх ухаан техникийн улсын хорооноос жил бүр шилдэг бүтээлийн уралдаан зарлаж, их наадам зохиож байгаа нь шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажилд ахиц гаргах нэг үндэс болдог ажээ.

Шинжлэх ухааны суурь судалгаа гол төлөв Хойд Солонгосын Байгалийн шинжлэх ухааны академи, Нийгмийн шинжлэх ухааны академиуд дээр төвлөрчээ. Мөн их дээд сургуулиудад ч судалгаа-шинжилгээний ажил өргөн цар хэмжээтэй явагдаж байна.

БНАСАУ-ын ард түмэн соёлын өнө эртний баялаг уламжлалтай билээ. Бүр Курё улсын үеэс уламжилж ирсэн түүх соёлын гайхамшигт дурсгалтай Умард Солонгосын ард түмэн соёлын дурсгалт зүйл-

сээ өвлөн уламжилж, нандигнан хамгаалахын зэрэгцээ шинэ соёлын дурсгалт зүйлсийг туурвин бүтээжээ. Энд юуны өмнө Чхоллима-гийн гэрэлт хөшөө зүй ёсоор орно. Солонгосын баатарлаг ард түмний ирээдүйг угтан зөгнөсөн далавчит морио унан нисэн дүүлж яваа солонгос эрийн энэ сүрлэг хөшөө 46 м өндөр юм. Түүнчлэн солонгосын хувьсгалын музейг нэрлэж болно. Энэ музей 54 мянган кв метр талбай эзлэх бөгөөд 2 кино танхим, 90 үзэсгэлэнгийн танхимтай юм. Мөн 45 мянган кв метр талбай бүхий Мансудэгийн их хурлын ордон, 2000 кв метр талбай бүхий Мансудэгийн уран сайхны театр зэрэг олон соёлын дурсгалт уран барилгаар алдартай. Үндэсний соёл, урлаг амжилттай хөгжиж байна.

БНАСАУ-ын засаг, төрөөс хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах талаар онцгой анхаарал тавьж ирсний нэг төл илрэл нь хүн амын дундач наслалт уртассан явдал юм. БНАСАУ-ыг тунхаглах үед хүн амын дундач нас 38,4 байсан бол 1986 оны байдлаар 74,6 болж, 10 мянган хүн тутамд эмнэлгийн 27 ажилтан оногдож байв.

БНАСАУ 1989 оны Дэлхийн Залуучууд оюутны XIII их наадмыг амжилттай зохион явуулсан билээ. Их наадамд зориулж «Кванбоккийн хороолол» нэртэй иж бүрэн цогцолбор барьж байгуулсан юм. Энэ цогцолбор 4 сая ам метр талбай дээр 200 орчим төрөл бүрийн барилга байгууламж барьжээ. Тухайлбал, спортын 4 ордон, 2 стадион, үйлчилгээний төвүүд, усан сан, дунджаар 100 орчим ам метр талбай бүхий 20 мянган айлын сууц зэргийг нэрлэж болох юм. Энэхүү цогцолбор одоо биеийн тамир, спортын төрөл бүрийн арга хэмжээ зохиоход их үүрэг гүйцэтгэж байна.

БНАСАУ олон улсын тавцан дээр энх тайванч гадаад бодлого явуулж, улс орнуудтай эрх тэгш харилцан ашигтай харилцаа тогтоохыг эрмэлздэг. Хойт Солонгос барууны хөгжингүй орнуудтай нэлээд болгоомжтой харьцдаг байсан бол еэрчлэлт шинэчлэлтийн өнөө үед гадаад орчинтойгоо харилцахдаа уян хатан бодлого баримтлах болов. Үүний нэг тодорхой жишээ бол 1992 онд гадаад хөрөнгө оруулалтын тухай хууль баталсан явдал юм. Умард Солонгосын холбоотон Хятад улс гаднаас хөрөнгө оруулж, эдийн засгайг шинэчилж гадаадын технологи авч хэрэглэхийг Умард Солонгост зөвлөсөн билээ. Энэхүү зөвлөлгөөг БНАСАУ хүлээн авч зохих хууль эрхийн актууд гаргалаа. Одоо Умард Солонгос хөдөө аж ахуй, барилга, тээвэр холбоо, шинжлэх ухаан, технологи, жуулчлал, худалдаа санхүүгийн салбарт гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрч байна. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулинд «Тус улс орчин үеийн технологи хэрэглэдэг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гаргадаг салбаруудад гадаадын хөрөнгө оруулахыг урамшуулан дэмжих болно» гэж заажээ. азрыг дээд зах нь 50 жилийн хугацаагаар түрээслэх, өвлөхийг зөвшөөрсөн байна.

Гадаадын мэдээллийн агентлагуудын уламжилснаас үзвэл БНАСАУ-д эдийн засгийн чөлөөт бүс байгуулсан аж. Тэр нь Солонгосын зүүн хойт нутагт нийтдээ 621 ам. метр нутгийг хамарч байна. Албан ёсоор чөлөөт эдийн засаг, худалдааны бүс гэж нэрлэжээ. Тэнд оршдог Нажин боомт гэхэд л чөлөөт худалдааны боомт болсон байна. БНАСАУ олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох болов. НУБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ивээл дор БНАСАУ, Хятад, Оросын хил дээр байрласан «Түмэн гол» бүсийн төслийг хэрэгжүүлэхэд Умард солонгос идэвхтэй оролцох төлөвтэй байна. 1992 оны эхээр «Түмэн гол» бүсийн эдийн засгийг хөгжүүлэх талаар БНАСАУ, БНСУ, Хятад, ОХУ, Монгол, Япон гэсэн 6 улсын Засгийн газар хоорондын байгууллага байгуулагдав.

Одоогийн байдлаар 15 жилийн хугацаанд хэрэгжүүлэх энэхүү төслийг боловсруулах ажлын хөтөлбөр гараад байна. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд Умард Солонгосын Чхонджин усан боомт орох юм. Энэхүү төсөлд БНАСАУ оролцож байгаа нь олон талын ач холбогдолтой. Хойд Солонгосын эдийн засгийн хөгжилд зохих нөлөө үзүүлж, олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох оролцоог нь юуны өмнө өргөтгөнө гэж Умард Солонгосын тал үзэж байна.

Өмнөд Солонгостой харилцах харилцаанд ч нааштай өөрчлөлт гарч байна. Хоёр Солонгос тус хойгийн цөмийн зэвсгийг хориглох гэрээнд өнгөрсөн жил гарын үсэг зурсан боловч хяналт шалгалтын тухай хэлэлцээнд тулж очоод мухарджээ. Өмнөд Солонгосын тал БНАСАУ-д химийн зэвсэг байна гэж мэдэгдэж байгаа боловч Хойд Солонгосын тал үүнийг няцаасан байна. Энэ мэт харилцан үл итгэлцэх, маргах асуудал Солонгосын хойгийн аюулгүй байдал, хамтын ажиллагаанд саад-тотгор болсоор байгаа ч гэсэн 1991 оны сүүлчээр Умард, Өмнөдийн эвлэрэх, үл довтолох, хамтын ажиллагаа, солилцоогоо өргөтгөх талаар тохиролцоонд хүрч эвийн гэрээ байгуулсан билээ. Умард, Өмнөд Солонгосын эдийн засаг, соёлын салбарын хамтын ажиллагаа ч сүүлийн үед идэвхжиж байна. Харилцан хүн солилцох явдал өргөжиж байна. Гэвч бүх зүйл дээр харилцан тохиролцож санал нийлж солонгосын хойгийн асуудал бүрэн шийдвэрлэгдэнэ гэсэн хэрэг биш. Солонгосын хойгийн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхэд дөхөм үзүүлэхүйц нааштай эхний алхамууд хоёр талын санаачилгаар хийгдэж байна гэж үзэж болох юм.

Манай улс БНАСАУ-тай 1948 оны аравдугаар сарын 15-нд дипломат харилцаа тогтоосон бөгөөд ЗХУ-ын дараа БНАСАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөврөөрсөн хоёр дахь орон юм. 1950—1953 онд Солонгосын хойгт болсон дайны хүнд хэцүү үед монгол, солонгосын ард түмний найрамдалт харилцаа өргөжин хөгжсөн юм. Дайны болон сэргээн босголтын жилүүдэд манай улс БНАСАУ-д хэр чинээнийхээ хэмжээгээр эд материалын тусламж дэмжлэг үзүүлж байв.

1951—1957 онд манай улс БНАСАУ-д 226 мянган гаруй толгой мал, 5 мянган тонн улаан буудай, 7,3 мянган тонн мах болон хүнсний бүтээгдэхүүн, 120 мянга гаруй ширхэг төрөл бүрийн хувцас бэлэг болгон өгчээ. Мөн эцэг эх нь дайнд амь үрэгдэж өнгөрсөн солонгосын 200 хүүхдийг 1952—1959 онд асран хүмүүжүүлж, солонгосын 30 гаруй оюутныг өөрийн их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцуулсан билээ.

1961 онд БНАСАУ өөрийн хүч хөрөнгөөр монгол солонгосын найрамдлын нэрэмжит Төв аймгийн Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдэлд сурагчдын дотуур байр, гуанз бүхий дунд сургуулийн байр барьж өгсөн юм. 1988 онд энэ сургуулийн анги танхимуудыг тохижуулахад зохих туслалцаа үзүүлжээ.

Сүүлийн үед хоёр орны худалдаа, эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа нэлээд өргөжиж байна.

Солонгосын тал манай пүүс, компаниудтай харилцаа тогтоож харилцан ашигтай хамтран ажиллах ажлын эхлэлийг тавиад байна. Энд юуны өмнө эмийн ургмал тариалах БНАСАУ, Монголын хамтарсан компанийг дурьдаж болох юм. Хоёр орны харилцаа нэг бүс нутгийн орны хувьд төдийгүй, олон улсын хамтын ажиллагааны шинэ төсөлд хамтарч ажиллахаар болж байгаагийн хувьд ч цаашид өргөжин тэлэх өргөн боломжтой юм.

1992 оны сүүлчээр Монгол улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны зөвлөлдөх комиссын Монголын хэсгийн урилгаар зөвлөлдөх комиссын БНАСАУ-ын хэсгийн дарга, БНАСАУ-ын Орон нутгийн үйлдвэрийн яамны сайд Ким Сон Гу тэргүүтэй төлөөлөгчид манай оронд айлчилж хоёр орны хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны цаашдын төлөвийн талаар ярилцаж тогтсон нь хоёр орны хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

- 1, Facts about Korea, Seoul, Korea 1991.
2. Земельный кодекс корейской народно-демократической республики. Корея, Пхеньян. 1992.
3. «Корея сегодня» ш 1992. № 4.
4. «Дорно дахины судлалын асуудал» № 2 (19) 1988.
5. «Ардын эрх» 1993. № 24.
6. «Өнөөдөр» 1993. № 13.
7. «Үнэн» 1993. № 8.
- 8, South-North dialogue in Korea. No, 53, December 1991,